



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/95

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий суманд өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан сэг зэм устгах тээврийн зардалд 550,000 (таван зуун тавин мянга) төгрөг, зудын хохирол учирсан айл өрхөд буцалтгүй тусламж 500,000 (таван зуун мянга) төгрөг, нийт 1,050,000 (нэг сая тавин) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1,050,000 (нэг сая тавин) төгрөгийг Эрсдлээс хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН